



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/246

Мандалгом

Газар эзэмших эрхийг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийг үндэслэн  
ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт ( Зоогийн 7-1 тоотын баруун талд) байршилтай Говийн ирээдүй цогцолбор сургууль (9033769)-ийн боловсролын байгууллагын барилга барих зориулалттай 10202 м.кв (1,0202 га) газраас 1924 м.кв (0,1924 га) газрыг Долдугаар цэцэрлэг /34302076/-т зориулалтаар нь 24 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр эрхийг шилжүүлж, үлдсэн 8278 м.кв ( 0.8278 га ) газрыг Говийн ирээдүй цогцолбор сургууль (9033769)-д зориулалтаар нь 24 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2012 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/328 тоот захирамжийн холбогдох хэсэг мөн газар эзэмших 0381942 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200700

